



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 72

Төрийн ордон, Улаанбаатар хот

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолд үндэслэн Барилга, хот байгуулалтын яамнаас баталгаажуулсан барилгын материалын үнийн өсөлтөөс үүдсэн төсөвт өртгийн нэмэгдлээс бусад улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдлийг Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн шаардлагатай бол төсвийн хуульд тусган шийдвэрлүүлэх;

2/Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;

3/Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;

4/Мэргэжлийн хяналтын зарим чиг үүргийг холбогдох яам, агентлагт шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн албан хаагчдыг зохих албан тушаалд хуваарилан томилох, бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдөх хүнд хуульд заасан тэтгэмж олгох;

5/Төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол

ашиг тооцон хуваарилж төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг чиглэл болгон ажиллах;

6/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулах;

7/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох, ашигт малтмал олборлох, боловсруулах, тээвэрлэх зэрэг бүх үе шатанд хамаарах гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлж, экспортод гаргах, нууцын зэрэглэлд хамаарах худалдах, худалдан авах гэрээг Улсын Их Хуралд танилцуулах;

8/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх, хувийн хэвшлийн зонхилох байр суурийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц судалгаа хийж, бодлого боловсруулах;

9/Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөрийг 2023 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авах;

10/Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэдэд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг үзүүлэх.

3.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР